



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 41,100,000.00 (дөчин нэгэн сая нэг зуун мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Багануурын дулааны станц" Төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Х.Энхбат, "Багануурын дулааны станц" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бүрэн эрхт төлөөлөгч Т.Батдондог нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005340

14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны... дугаар сарын...-ны өдрийн
... Дугаар тогтоолын хавсралт

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, "Багануур Дулааны станц" ТӨХК-нд балансаас
балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжи х нэгж	Балансын үнэ(төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл(төгрөг)	Үлдэх өртөг(төгрөг)
1	УАЗ Фургон	2021	1	Ш	41,100,000	-	41,100,000
Нийт							41,100,000
							(дөчин нэгэн сая нэг зуун мянга)